

МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ТОЙМ



Валют, эдийн засгийн газар

2010 оны жилийн эцсийн гүйцэтгэл

Үндсэн дансдууд: /сая ам.доллараар/

- Урсгал данс (886.7)
- Хөрөнгө ба Санхүүгийн данс 1743.7
- Цэвэр нөөцийн өөрчлөлт 873.1

Үзүүлэлт	Жилээр		Өөрчлөлт	
	2009	2010	Монгол дүн	Хувь
I. Урсгал Тэнцэл	-341.8	-886.7	-544.9	159%
<i>А. Бараа ба үйлчилгээний худалдаа</i>	<i>-332.0</i>	<i>-474.9</i>	<i>-142.9</i>	<i>43%</i>
<i>а. Бараа (1-2)</i>	<i>-188.8</i>	<i>-180.4</i>	<i>8.4</i>	<i>-4%</i>
1. Экспорт Ф.О.Б.	1,885.4	2,908.5	1,023.1	54%
2. Импорт Ф.О.Б.	-2,074.2	-3,088.9	-1,014.7	49%
<i>б. Үйлчилгээ</i>	<i>-143.2</i>	<i>-294.5</i>	<i>-151.3</i>	<i>106%</i>
1. орлого	414.5	486.0	71.5	17%
2. зарлага	-557.8	-780.5	-222.7	40%
<i>Б. Цэвэр орлого</i>	<i>-195.4</i>	<i>-598.8</i>	<i>-403.4</i>	<i>206%</i>
<i>В. Урсгал шилжүүлэг</i>	<i>185.7</i>	<i>187.0</i>	<i>1.3</i>	<i>1%</i>
<i>а. Ажилчдын гуйвуулга</i>	<i>120.1</i>	<i>129.4</i>	<i>9.3</i>	<i>8%</i>
1. Хүлээн авсан	191.5	247.9	56.4	29%
2. Шилжүүлсэн	-71.4	-118.5	-47.2	66%
<i>б. Бусад шилжүүлэг</i>	<i>65.5</i>	<i>57.6</i>	<i>-7.9</i>	<i>-12%</i>

Гол үзүүлэлтүүдийг 2009 онтой харьцуулахад:

- Урсгал тэнцлийн алдагдлын ДНБ-нд эзлэх хувь хэмжээ 2010 онд 10.7%-д хүрч, өмнөх оноос 7.8 нэгж хувиар өссөн нь урсгал тэнцэл тогтворгүйжих эрсдэлийг нэмэгдүүлсэн үзүүлэлт болов.
- Барааны гадаад худалдааны алдагдал 180.4 сая ам.долларт хүрч 4%-иар өсөв.
- Үйлчилгээний дансны алдагдал 294.5 сая ам.долларт хүрснээр алдагдлын хэмжээ нь 106%-иар өсөв. Тээвэр, аялал жуулчлал, харилцаа холбоо, санхүү, барилга, даатгал, патент ба лиценз, компьютер ба мэдээлэл, бизнес, Засгийн газрын зэрэг Монгол Улсын үйлчилгээний секторууд бүгд алдагдалтай байна.
- Цэвэр орлогын дансны алдагдал 598.8 сая ам.долларт хүрсэн нь 3.1 дахин өссөн үзүүлэлт болов. Энэ нь Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн гадагш шилжүүлсэн орлогын хэмжээ хурдацтай өсч буйг харуулж байна.
- Урсгал шилжүүлэг цэвэр дүнгээр 187.0 сая ам.долларын ашигтай гарсан нь өмнөх оноос 1%-иар өссөн үзүүлэлт юм.
- Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 1629.7 сая ам.долларт хүрч 2.9 дахин, багцын хөрөнгө оруулалтын данс цэвэр дүнгээр 894.3 сая ам.долларын ашигтай гарсан нь санхүүгийн дансны ашгийг 2.3 дахин нэмэгдэхэд нөлөөлөв.

Үзүүлэлт	Жилээр		Өөрчлөлт	
	2009	2010	Монгол дүн	Хувь
Санхүүгийн данс	608.3	1 591.5	983.2	162%
<i>а. Шууд хөрөнгө оруулалт</i>	<i>569.8</i>	<i>1 629.7</i>	<i>1 059.9</i>	<i>186%</i>
<i>б. Багцын хөрөнгө оруулалт</i>	<i>-82.1</i>	<i>894.3</i>	<i>976.4</i>	<i>-1189%</i>
<i>в. Бусад хөрөнгө оруулалт</i>	<i>120.6</i>	<i>-932.4</i>	<i>-1 053.1</i>	<i>-873%</i>

Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтэс
Валют, эдийн засгийн газар

Монголбанк

Бага тойруу 3, Улаанбаатар 15160

Утас: 976-11-323243, 318304, 327088

bop@mongolbank.mn

УРСГАЛ ДАНС

- 2010 онд урсгал тэнцлийн алдагдал 886.7 сая ам.долларт хүрч, 2009 онтой харьцуулахад 2.6 дахин өссөн бол хөрөнгө, санхүүгийн тэнцлийн ашиг 1743.7 сая ам.доллар буюу 2.3 дахин өссөн нь нийт төлбөрийн тэнцэл 873.1 сая ам.долларын ашигтай буюу 2009 оноос 57%-иар сайжрахад нөлөөлжээ.
- Бараа үйлчилгээний данс 474.9 сая ам.долларын, цэвэр орлогын данс 598.8 сая ам.долларын алдагдалтай гарсан нь урсгал тэнцлийн алдагдал нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна.
- Хэдий нийт барааны худалдааны эргэлт өнгөрсөн оноос 51%-иар нэмэгдсэн ч барааны худалдааны экспорт, импортын өсөлтийн хурд ойролцоо байснаас барааны гадаад худалдааны алдагдал өнгөрсөн онтой харьцуулахад тогтвортой байна.
- Үйлчилгээний худалдааны эргэлтийн дунджаар 85%-ийг тээвэр, аялал жуулчлал болон бизнесийн бусад үйлчилгээ эзэлж байна. Эдийн засгийн тэлэлт, уул уурхайн төслийн эрчимжилттэй холбоотойгоор импортын барааны тээвэрлэлтийн зардал өнгөрсөн оны мөн үеэс 1.5 дахин өсч 214.8 сая ам.долларт, бусад бизнесийн үйлчилгээний зардал 66.7%-иар өсч 139.2 сая ам.долларт тус тус хүрчээ.
- Монгол Улсын Засгийн газар, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж /ААН/, иргэд нь эдийн засгийн харьяат бусаас авсан гадаад зээл, өрийн бичиг болон харилцах, хадгаламжийн хүүгийн төлбөрт 91.1 сая ам.долларыг, хөрөнгө оруулалтын ногдол ашигт 475.5 сая ам.долларыг тус тус төлсөн нь цэвэр орлогын данс 598.8 сая ам.долларын алдагдалтай гарахад нөлөөлсөн байна.
- Гадаадын улс орнуудад ажиллаж, амьдарч буй иргэдээс хүлээн авсан гуйвуулгын дүн өмнөх оны мөн үеэс 29.0%-иар өсч, харин гадаадын улс орнууд руу шилжүүлсэн хувийн гуйвуулгын хэмжээ 66%-иар өсч, ажилчдын цэвэр гуйвуулгын дүн 8%-иар өсчээ. Энэ нь Япон, БНСУ, ОХУ-аас хүлээн авсан цэвэр гуйвуулгын дүн өссөнөөс шалтгаалжээ.

САНХҮҮГИЙН ДАНС

- Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 1691.4 сая ам.доллар байгаа нь манай улсын ашигт малтмал, уул уурхайн салбарт орсон гадаадын шууд хөрөнгө оруулалт 1231.9 сая ам.долларт хүрч, өнгөрсөн онтой харьцуулахад 5.7 дахин буюу 1016.19 сая ам.доллараар өссөнтэй холбоотой.
- Төлбөрийн тэнцлийн аргачлалын дагуу шууд хөрөнгө оруулалтын дансанд хувь нийлүүлэгчийн оруулсан бүхий л хөрөнгийг бүртгэдэг бөгөөд үүнд эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл болон бусад санхүүжилтүүд багтдаг. Энэ аргачлалаар тооцход, 2010 онд эдийн засгийн харьяат ААН-үүд гадны хөрөнгө оруулагчаас цэвэр дүнгээр 360.4 сая ам.долларын эх үүсвэрийг авч ашигласан нь өнгөрсөн оноос 2.7 дахин нэмэгдсэн байна.
- Багцын (санхүүгийн) хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 894.3 сая ам.доллар хүртэл нэмэгдсэн нь (i) "Монголиан майнинг корпорэйшн" компани Гонгконгийн хөрөнгийн биржээс 2010.10.13-ны өдөр 651.0 сая ам.долларыг босгосон, (ii) Худалдаа, хөгжлийн банк 2007 онд гаргасан 75 сая ам.долларын бондын үлдэгдэл болох 41.3 сая ам.долларын бондыг тайлант онд эргүүлэн худалдан авсны зэрэгцээ 175.0 сая ам.долларын бондыг 10 дугаар сард шинээр гаргасан зэрэгтэй голлон холбоотой байна.
- Монгол Улсын Засгийн газрын шугамаар болон түүний баталгаатайгаар хандивлагч орон болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас тайлант онд 65.8 сая ам.доллартай тэнцэх зээл авч, 51.4 сая ам.долларын үндсэн төлбөрийг төлжээ.
- Худалдааны зээл 63.1 сая ам.долларын эерэг урсгалтай гарсан нь ААН-үүдийн эдийн засгийн харьяат бусаас хүлээн авсан экспортын урьдчилгаа төлбөрийн хэмжээг харуулж байна.
- Тайлант оны эцсийн байдлаар хувийн хэвшлийн нийт гадаад өрийн үлдэгдэл 1,980.5 сая ам.долларт хүрч, 2009 оноос 2.2 дахин өссөн.






ГАДААД ВАЛЮТЫН ЦЭВЭР АЛБАН НӨӨЦ

- Монгол Улсын гадаад валютын цэвэр албан нөөцийн хэмжээ 2010 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 2,091.2 сая ам.долларт хүрчээ. Энэ нь 21.2 долоо хоногийн импортын (2011 оны импортын төсөөллөөр) хэрэгцээг хангах түвшинд байна.


АЛДАА БОЛОН ОРХИГДУУЛГА

- Тайлант онд алдаа ба орхигдуулга үзүүлэлт абсолют дүнгээр 16.1 сая ам.доллар гарч, өнгөрсөн оны мөн үеэс 8 дахин буурсан байна.



Хавсралт 1. Урсгал дансны хүснэгт, график



Үзүүлэлт	Жилээр		Өөрчлөлт	
	2009	2010	дүн	Хувь
Жуулчлалын салбарын нийт орлого	189.7	208.5	18.9	10.0%
Гадаадын жуулчдын тоо	282,524.0	311,298.0	28,774.0	10.2%
Жуулчлалын салбарын нийт зардал	177.9	207.9	30.0	16.9%
Гадаадад жуулчилсан	340,136.8	404,397.0	64,260.2	18.9%
Жуулчлалын цэвэр орлого (сая)	11.8	0.6	(11.2)	-94.9%



Хавсралт 2. Санхүүгийн дансны хүснэгт, график



Хавсралт 3. Төлбөрийн тэнцэлд тохируулга хийх

- Төлбөрийн тэнцлийн жилийн дүн эцэслэн гарах хүртэлх хугацаанд шаардлагатай тохиолдолд улирлын нэгтгэлд өөрчлөлт хийдэг.
- Аль улирлын өөрчлөлт болохыг тодорхойлох боломжгүй үед өөрчлөлтийг 4 дүгээр улиралд оруулна.
- Гадаад худалдааны гаалийн жилийн статистикт өөрчлөлт орохтой холбогдон урьдчилсан байдлаар нэгтгэн гаргасан төлбөрийн тэнцлийн урсгал дансны гүйлгээний дүн өөрчлөгддөг.
- Урьдчилсан байдлаар гаргасан төлбөрийн тэнцэлд холбогдох өөрчлөлтийг тусгаж эцэслэн 2 дугаар улиралд багтаан гаргадаг.

Хавсралт 3.1 Төлбөрийн тэнцлийн хураангуй (сая ам.доллараар)

Үзүүлэлт	Жилээр		Өөрчлөлт	
	2009	2010	Мөнгөн дүн	Хувь
I. Урсгал Тэнцэл (А+В+С)	-341.8	-886.7	-544.9	159%
А. Бараа ба үйлчилгээний худалдаа (1+2)	-332.0	-474.9	-142.9	43%
1. Бараа	-188.8	-180.4	8.4	-4%
1.1 Ерөнхий эд бараа	-471.8	-338.1	133.7	-28%
Экспорт Ф.О.Б. (Кредит)	1,572.4	2,729.5	1,157.1	74%
Үүнээс: Зэсийн баяжмал	501.8	770.6	268.7	54%
Импорт Ф.О.Б. (Дебит)	-2,044.2	-3,067.6	-1,023.5	50%
Үүнээс: Нефтийн бүтээгдэхүүн	-523.6	-672.4	-148.8	-28%
Хүнсний бүтээгдэхүүн	-193.4	-336.2	-142.8	-74%
1.2 Мөнгөжөөгүй алт	308.5	178.3	-130.1	-42%
Кредит	308.5	178.3	-130.1	-42%
Дебит	0.0	0.0	0.0	
1.3 Бусад	-25.5	-20.6	4.9	-19%
Кредит	4.5	0.6	3.9	87%
Дебит	-30.0	-21.2	6.7	-21%
2. Үйлчилгээ	-143.2	-294.5	-151.3	106%
2.1 Тээвэр	-67.7	-110.5	-42.8	63%
Кредит	135.6	174.6	39.0	29%
Дебит	-203.3	-285.1	-81.8	40%
2.2 Аялал	24.9	-21.2	-46.1	-185%
Кредит	235.3	244.0	8.8	4%
Дебит	-210.4	-265.3	-54.9	26%
2.3 Бусад үйлчилгээ	-100.4	-162.7	-62.3	62%
Кредит	43.7	67.3	23.7	54%
Дебит	-144.1	-230.1	-86.0	60%
В. Орлого (1+2)	-195.4	-598.8	-403.4	206%
1. Ажиллагсдын цалин хөлс	-3.9	-32.2	-28.3	717%
Кредит	8.1	18.3	10.2	
Дебит	-12.1	-50.6	-38.5	319%
2. Хөрөнгө оруулалтын орлого	-191.5	-566.6	-375.1	196%
Кредит	16.2	10.6	-5.6	-35%
Дебит	-207.7	-577.2	-369.5	178%
С. Урсгал шилжүүлэг (цэвэр)	185.7	187.0	1.3	1%
Кредит	260.3	309.4	49.1	19%
Дебит	-74.6	-122.4	-47.8	64%
Үүнээс: Ажиллагсдын гуйвуулга	120.1	129.4	9.3	8%
Кредит	191.5	247.9	56.4	29%
Дебит	-71.4	-118.5	-47.2	66%
0.0				
II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл (А+В)	768.8	1,743.7	974.9	127%
А. Хөрөнгийн данс	160.5	152.2	-8.3	
Кредит	160.5	152.7	-7.8	
Дебит	0.0	-0.5	-0.5	
В. Санхүүгийн данс (1+2+3+4)	608.3	1,591.5	983.2	162%
1. Шууд хөрөнгө оруулалт	569.8	1,629.7	1,059.9	186%
1.1 Гадагш хийсэн	-53.8	-61.7	-7.9	15%
1.1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө	0.4	-46.7	-47.1	-12206%
1.1.2 Орлогын дахин хөрөнгө оруулалт	0.0	0.6	0.6	0%
1.1.3 Бусад хөрөнгө	-54.2	-15.6	38.6	-71%
1.2 Монголд орсон	623.6	1,691.4	1,067.8	171%
1.2.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө	504.1	1,218.0	713.9	142%
1.2.2 Орлогын дахин хөрөнгө оруулалт	-16.1	113.0	129.1	
1.2.3 Бусад хөрөнгө	135.6	360.4	224.8	166%
2. Багцын (санхүүгийн) хөрөнгө оруулалт	-82.1	894.3	976.4	-1189%
2.1 Актив	-138.8	143.3	282.1	-203%
2.1.1 Хөрөнгийн хувьцаа	-6.4	-12.9	-6.5	101%
2.1.2 Өрийн бичиг	-132.4	156.2	288.6	-218%
2.1.2.1 Бонд, үнэт цаас	0.0	2.1	2.1	0%
2.1.2.2 Мөнгөний захын хэрэгсэл	-132.4	154.1	286.5	-216%
2.2 Пассив	56.7	751.0	694.3	1224%
2.2.1 Хөрөнгийн хувьцаа	3.6	680.3	676.7	18909%
2.2.2 Өрийн бичиг	53.1	70.7	17.6	
2.2.2.1 Бонд, үнэт цаас	53.1	70.7	17.5	33%
2.2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл	0.0	0.0	0.0	0%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (цэвэр)	0.0	0.0	0.0	0%
3.1 Актив	0.0	0.0	0.0	0%
3.2 Пассив	0.0	0.0	0.0	0%
4. Бусад хөрөнгө оруулалт	120.6	-932.4	-1,053.1	-873%
4.1 Актив	-144.8	-1,040.2	-895.4	618%
4.1.1 Худалдааны зээл	10.8	-4.0	-14.8	-137%
4.1.2 Зээл	5.2	4.4	-0.8	-16%
4.1.3 Бэлэн мөнгө ба харилцах	-160.8	-1,040.6	-879.8	547%
4.1.4 Бусад актив	0.0	0.0	0.0	0%
4.2 Пассив	265.5	107.8	-157.7	-59%
4.2.1 Худалдааны зээл	3.6	63.1	59.5	1642%
4.2.2 Зээл	230.7	113.5	-117.1	-51%
4.2.2.1 Төв банк	-1.6	-1.3	0.2	
4.2.2.2 Засгийн газар	149.7	9.6	-140.1	-94%
4.2.2.3 Банк	60.3	-8.9	-69.2	-115%
4.2.2.4 Бусад сектор	22.2	114.2	91.9	413%
4.2.3 Бэлэн мөнгө ба харилцах	-44.9	-68.9	-23.9	53%
4.2.4 Бусад пассив	76.1	0.0	-76.1	
III. Алдаа болон орхидуулга	128.5	16.1	-112.4	-87%
Төлбөрийн тэнцлийн нийт дүн (I+II+III)	555.5	873.1	317.6	57%
IV. Гадаад валютын цэвэр нөөцийн өөрчлөлт (1+2)	-555.5	-873.1	-317.6	57%
1. Актив	-712.8	-891.8	-179.0	
1.1 Мөнгөжөөсөн алт	27.0	0.0	-27.0	
1.2 Зээлжих тусгай эрх	-76.4	4.1	80.5	
1.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө	0.0	0.0	0.0	
1.4 Бэлэн валют ба харилцах	-656.6	-905.9	-249.3	
1.5 Бусад нөөц актив	-6.7	10.0	16.8	
2. Пассив	157.3	18.7	-138.6	
2.1 ОУВС-ийн зээл	157.3	18.7	-138.6	
2.2 Онцгой санхүүжилт	0.0	0.0	0.0	